

Монгол Улс
НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд Орхон, Хөвсгөл, Архангай, Булган аймгийн засаг захиргааны төлөөллөөс санал авах уулзалт
2017 оны 9-р сарын 8

Дэлхийн Банк Групп нь (ДБГ) Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодлыг сонсох, солилцох зорилгоор 2017 оны 9 дугаар сарын 8-нд Орхон, Хөвсгөл, Архангай, Булган аймгийн засаг захиргаа, иргэдийн төлөөлөгчдийн хурлын 25 төлөөлөгчтэй уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

1. Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
2. Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
3. Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
<p style="text-align: center;">Дүн шинжилгээний талаар ирүүлсэн санал (боломж, сорилт, тулгамдсан асуудал ба ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга замууд)</p>	<p>Боломж</p> <ul style="list-style-type: none"> • Монгол бол байгалийн баялгаар арвин нөөцтэй улс тул цаашид уул уурхайд түшиглэн хөгжих боломж бий. Зөвхөн уул уурхайгаас гадна үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж байна. Шинжлэх ухаан, технологи, инновацийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн төрийн өмчит аж ахуйн нэгжүүд энэ тал дээр туслах боломжтой. • Монгол улсын нийгмийн даатгалын үйлчилгээ нь дэлхийд тэргүүн туршлага болохуйц хэмжээнд хүрсэн – нийгмийн даатгалын тогтолцоонд 38 төрлийн үйлчилгээ үзүүлж байна. • Хөвсгөл аймаг нь аймгийнхаа хөгжлийн стратегийг боловсруулсан бөгөөд энэ нь ДБГ-тэй хамтран ажиллах боломжуудыг тодорхойлоход тусална. • Хүн ам төвлөрсөн хотууд (Улаанбаатар, Дархан, Эрдэнэт) өрсөлдөх давуу талтай. <p>Сорилтууд</p> <ul style="list-style-type: none"> • Монгол улсын засаг захиргааны хуваарилалт нь улсын хэмжээнд төрийн үйлчилгээг үр ашигтай үзүүлэхэд тохиромжгүй. Жишээ нь, Эрдэнэт хотыг Орхон аймагт харьяалуулсан. Бүс нутгийн хөгжил нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан боловч бодит амьдралд огт хэрэгжиж эхлээгүй байна. Нэг бүст харьяалагдаж буй аймгууд хөгжлийн түвшнээрээ ялгаатай учраас зарим аймгууд төсөвт бага орлого бүрдүүлж байгаа ч төрөөс бүрдүүлсэн орлоготой харьцуулахад илүү татаас авах явдал үргэлжилсээр байна. Бүсийн хөгжлийн стратеги боловсруулахдаа орон нутгийн өвөрмөц шинж чанарыг анхаарч үзэх нь зүйтэй. • Сайн засаглалыг бэхжүүлэхийн тулд төр болон бусад оролцогч талуудын хоорондын хамтын ажиллагаа дутагдалтай байгааг анхаарах нь зүйтэй. Төр, иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ), хувийн хэвшлийн хамтын ажиллагааны механизмыг бий болгох хэрэгтэй. Төр-хувийн хэвшлийн түншлэлийн зохицуулалтыг цаашид сайжруулан хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай.

	<ul style="list-style-type: none"> • ИНБ-уудын чадавх сул хэвээр байна. Мэдээллийн хүртээмж хязгаарлагдмал хэвээр байгаа учраас хүн амын ихэнх хэсэг нь мэдээлэлгүй үлдэж байна. Иймд үндсэн хуулийн хэрэгжилтийг хангах, аливаа ажлын үр дүн/үр ашгийг дээшлүүлэхийн тулд олон нийтийн оролцоо, чадавхийг бэхжүүлэх хүчин чармайлт гаргах хэрэгтэй. • Улс төрийн тогтворгүй байдал нь том сорилт болж байна. Үүний үр дагаварт нийгмийн хамгааллын бодлого гэх мэт төрийн бодлого тогтворгүй болсон. • Уул уурхайн үйл ажиллагаа болон хүний хүчин зүйлийн улмаас байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэг гэх мэтээр байгаль орчны асуудлууд тулгамдсан хэвээр байна. Жишээ нь модны үнэ буурсан зэргийг үл харгалзан модны үйлдвэрлэл үргэлжилж байгаа явдал ой модыг сүйтгэж байна. Усны чанар доройтож байна. Хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор агаар, хөрсний бохирдол нэмэгдэж байна - орон сууцжуулах хөтөлбөр эдгээр асуудлыг шийдвэрлэхэд тусалж болох юм. Байгалийн нөөцийн менежментийг сайжруулах шаардлагатай. • Ус, цэвэрлэх байгууламж, дэд бүтэц муудсан, шинэчлэн засварлах шаардлагатай. • Бизнес эрхлэх тэгш боломжийг зөвхөн хууль эрх зүйн орчинд бүрдүүлсэн боловч бодит амьдралд хэрэгждэггүй. Орлого, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх нь хүмүүсийн хувьд нэн тэргүүний асуудал юм. ЖДҮ эрхлэгчид нь оффис-албан тасалгаа, газрын зөвшөөрөл авахад хүндрэлтэй байдаг. Газрын зөвшөөрөл олгодоггүй, олгосон зөвшөөрлийг төр өөрчлөгдөхөд хүчингүй болгодог. • Мал амьтны эрүүл мэндийн асуудал тулгамдсан хэвээр байна. Мал, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх хэрэгтэй. • Зээлийн хүү хэт өндөр байна. • Эрүүл хооллолт, эрүүл амьдралын хэв маягийн талаарх малчдын мэдлэг хангалтгүй. Хүнсний аюулгүй байдал, хамгаалал нь хүмүүсийн санааг зовоосон асуудал болж байгаа тул энэ талаар иргэдийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарах хэрэгтэй. • Үерээс хамгаалах системийг сайжруулахад хөрөнгө оруулалт хангалтгүй байна. • Ерөнхий хууль эрх зүйн хүрээ, хууль тогтоомжуудыг сайн боловсруулж баталдаг ч хэрэгжилт, хууль биелүүлэлт муу байна. • Хөдөө орон нутагт гэр бүлийн хүчирхийлэл тулгамдсан асуудал болжээ.
<p>ДБГ-ийн стратеги ба түншлэлийн талаарх санал</p>	<ul style="list-style-type: none"> • Нэн тэргүүний хөгжлийн чиглэлийг Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-тай уялдуулах. • Шинжлэх ухаан ба мэдлэгт суурилсан эдийн засгийн хөгжлийг дэмжих. Мөн экологид ээлтэй бизнесийг дэмжих. • Ядуурлаас ангижрахын тулд хүний хөгжлийг хангах, ялангуяа боловсролыг дэмжих ёстой. Хүний хөгжлийн ач холбогдлыг ойлгосон ч одоогийн холбогдох бодлого, хууль тогтоомж хэрэгжихгүй байна. Хүний хөгжил нь хүүхдийг багаас нь төлөвшүүлэх, хүмүүжүүлэхээс эхэлдэг. Жишээ нь эрүүл мэнд, бага насны хүүхдийн боловсрол гэх мэт. Бүх түвшинд багш нарын боловсролыг дээшлүүлэх нь чухал. Хувь хүний санхүү, өөрийн амьдралдаа сонголт хийх, шийдвэр гаргах талаар олон нийтийн боловсролыг дээшлүүлэхэд туслах. Иргэдийн сэтгэхүй, сэтгэлгээ буруу чиглэлд явж байгаа байдал ажиглагдаж байгаа учраас иргэдийн сэтгэлгээг өөрчлөх, соён гэгээрүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Хүмүүс илүү их шашинлаг болж байна. Хөдөө орон нутаг, аймгийн төвүүдэд хүний хөгжлийн төвийг байгуулах хэрэгтэй.

	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэнд, боловсрол нь ДБГ-ийн дэмжлэг үзүүлэх чухал салбарууд мөн. • Төр, ИНБ-ын хамтын ажиллагааг сайжруулах; төрийн зарим үйлчилгээг ИНБ-уудаар хийлгэх чиглэлээр ИНБ-ыг чадавхжуулах. • Авилгалтай тэмцэх, уул уурхайгаас олсон орлогын тэгш хуваарилалтыг хангахад туслах. Мөн засаглалыг бэхжүүлэх (төрийн үйлчилгээг сайжруулах), уул уурхайн салбарт компаниудын санхүүжилт, зарцуулалт, засаглалыг ил тод болгоход дэмжлэг үзүүлэх. • ЖДҮ-ийн хөгжлийн бодлого, хэрэгжүүлэлтийн талаар судалгаа хийж Монгол улсын чиг хандлага зөв эсэх, цаашдын хөгжлийн чухал асуудлуудыг тодорхойлох нь зүйтэй. • Дэд бүтцийн хөгжилд хөрөнгө оруулах. • Улсын төсвийн зарцуулалт, төсвийн хэмнэлтийн үр ашгийг нэмэгдүүлэх, олон нийтийн хэрэгцээ шаардлагыг шийдвэрлэхийн тулд хөрөнгө оруулалтыг ач холбогдлоор нь эрэмбэлэхэд дэмжлэг үзүүлэх. • Хотын захын дүүргүүд, хөдөө орон нутагт үйлчилгээний тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх. Нийгэмд тэгш бус байдал гүнзгийрэхээс сэргийлж дундаж амьжиргаатай хүн амыг хөгжүүлэхэд анхаарах. • Өрхийн орлого, хүнсний аюулгүй байдлыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх. Зөвхөн ядуучууд бус дунд орлоготой иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжих. • Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж гэр бүлийн гишүүдийг хамгаалах зорилгоор аймгуудад гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн түр байрлах газруудыг барих хэрэгтэй.
	<p>Арга зам ба хэрэгжилт:</p> <ul style="list-style-type: none"> • Чадавх бэхжүүлэх үйл ажиллагаанд олон улсын зөвлөхүүдийн оронд орон нутгийн зөвлөхүүдийг түлхүү ашиглах. • Зөвлөгөө өгөх, дүн шинжилгээ хийх, чадавх бэхжүүлэх зэрэг бүх төрлийн дэмжлэг туслалцааг үзүүлэх. Ийм төрлийн дэмжлэг туслалцааг хангалттай үзүүлсэн тохиолдолд санхүүгийн дэмжлэг шаардлагагүй байж болох юм. • ДБГ-ийн тусламж дэмжлэг тухайн зорилтот бүлэг буюу үр шим хүртэгчдэд хүрч буй эсэхийг хянан баталгаажуулж, үр дүнг хянах. ЖДҮ-ийн зээл, тусламжийн санхүүжилт нь зорилтот үр шим хүртэгчдэд хүрч чаддаггүй, үр нөлөө нь богино хугацаатай байдаг учраас томоохон хэмжээний аж үйлдвэрийг санхүүжүүлбэл ажлын байр бий болгоход тустай. • Зарим тохиолдолд ДБГ-ийн дүн шинжилгээ судалгаа, нөлөөлийн ажлууд нь санхүүжилтын дэмжлэг туслалцаанаас илүү үнэ цэнэтэй байдаг. • Орон нутгийн нөхцөл байдалд тохирсон аргачлалыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавихад туслахын тулд аймаг бүрт Дэлхийн банкны төлөөлөгчтэй байх
<p>ДБГ-ийн зөвлөлдөх уулзалтуудын талаарх санал</p>	<ul style="list-style-type: none"> • Ядуу өрхүүдэд чиглэсэн ажлын байр бий болгох, бичил бизнесийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. • ДБГ-ийн өмнөх туршлагад тулгуурлан хууль эрх зүйн шинэчлэлийг дэмжих ажлыг үргэлжлүүлэх. • Иргэдийн аюулгүй байдал, хамгааллыг хангах үүднээс гудамжны камер суурилуулах ажлыг дэмжих. • Гэр бүлийн хүмүүжил, зарчим, бага насны хүүхдийн хөгжил, боловсролын ач холбогдлыг сурталчлах төслийг хэрэгжүүлэх

Бусад	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн нөхцөл байдалд тохирсон бодлого боловсруулж хэрэгжүүлэх нь хөгжлийн чухал хүчин зүйл мөн.
--------------	--

Уулзалтын үеэр авсан судалгааны дүн:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	20	80%
— Төрийн удирдлага/шинэтлэл	8	32%
— Боловсрол	8	32%
— Хувийн хэвшлийг хөгжүүлэх	7	28%
— Хүнсний аюулгүй байдал	7	28%
— Авилгатай тэмцэх	6	24%
— Эдийн засгийн өсөлт	6	24%
— Гадаадын хөрөнгө оруулалт	5	20%
— Эрүүл мэнд	4	16%
— Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	4	16%
— Хотын хөгжил	4	16%
— Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	3	12%
— Зам, тээвэр	3	12%
— Худалдаа, экспорт	3	12%
— Нийгмийн хамгаалал	3	12%
— Хөдөөгийн хөгжил	2	8%
— Эрх тэгш боломжоор хангах	2	8%
— Санхүүгийн зах зээл	2	8%
— Байгалийн нөөцийн удирдлага	1	4%
— Гамшгийн эрсдлийн удирдлага	1	4%
— Эрчим хүч	1	4%
— Ус, ариун цэврийн байгууламж	1	4%
— Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах	1	4%
— Бусад:	0	0%

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Хүний хөгжлийг дэмжих	17	68%
— Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	11	44%
— Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	9	36%
— Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	7	28%
— Дэд бүцтийн хөрөнгө оруулалтыг дэмжих	7	28%
— Дээрх бүгд чухал	1	4%

